

ДАМЖУУЛАН ОЛГОХ ТӨСЛИЙН ЗЭЭЛҮҮДИЙН 2016 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

Монгол улсын Засгийн газар 1994 онд Азийн хөгжлийн банктай, 1995 онд ХБНГУ-ын Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу Монголбанк КфВ банк болон АХБ-ны төслийн зээлийг банкуудад дамжуулан олгох үүрэгтэй оролцож байна.

1. КфВ банкны ЖДҮ-ийг дэмжих төслийн зээл

Төслийн зорилго: Экспортын чиглэлийн ЖДҮ-ийг хөгжүүлэх, санхүүгийн секторыг дэмжих.

Эх үүсвэр: Монгол улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 40 жилийн хугацаатай 8.7 сая еврогийн зээлийг жилийн 0.75 хувийн хүүтэйгээр хүлээн авсан.


КфВ банкнаас Монголбанкинд олгосон зээлийн эргэн төлөлт: Монголбанк КфВ банкинд жилд 2 удаа хуваарийн дагуу эргэн төлөлт хийдэг бөгөөд анх зээл авсанаас хойш нийт 2.5 сая еврог КфВ банкинд төлсөн. Ингэснээр энэхүү зээлийн үлдэгдэл 2016 оны эцсийн байдлаар 6.18 сая евро байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. КфВ төслийн зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл /евро/

	2015.IV	2016.I	2016.II	2016.III	2016.IV
Эхний үлдэгдэл	6 610 969,74	6 469 117,87	6 469 117,87	6 327 266,00	6 327 266,00
Үндсэн зээлийн төлбөр	141 851,87	0,00	141 851,87	0,00	141 851,87
Хүүгийн төлбөр	24 791,13	0,00	24 259,19	0,00	23 727,25
Эцсийн үлдэгдэл	6 469 117,87	6 469 117,87	6 327 266,00	6 327 266,00	6 185 414,13

Монголбанкнаас Банкинд олгосон зээл: Банкнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монголбанк 250 000 хүртэлх еврог 5 жилийн хугацаатай банкуудад дамжуулан олгодог. Банк Монголбанкинд жилд 2 удаа хуваарийн дагуу буцаан төлдөг бөгөөд оролцогч банкинд олгосон зээлийн үлдэгдэл 4.69 сая евро байна.

Зураг 1. КфВ төслийн зээлийн үлдэгдэл, дамжуулан олгосон дүн



Эх үүсвэрийн ашиглалт

Тайлант хугацааны эцсийн байдлаар хөтөлбөрийн эргэлтийн сангийн хөрөнгийн 75.8 хувийг дамжуулан олгосон байна. Үүний 49.2 (2.3 сая евро) хувийг ХХБ, 37.4 (1.8 сая евро) хувийг Голомт банк, 13.4 (0.6 сая евро) хувийг УБ хотын банк ашиглаж байна (Зураг 2).

Зураг 2: КфВ төслийн зээлийн эргэлтийн сангийн эх үүсвэрийн хуваарилалт



Банкуудын ААН-д олгосон зээл: КфВ банкны төсөл манай улсад хэрэгжиж эхэлснээс хойш уг төсөлд нийт 149 ЖДҮ зээлд хамрагдаж, 63.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл авсан байна. Тайлант улирлын эцсийн

*-Зах зээлийн хүүтэй уялдсан, Дэлхийн банкны “Хувийн хэвшлийг хөгжүүлэх хөтөлбөрийн”-ийн хүүнээс ихгүй.

байдлаар 58 ЖДҮ эрхлэгч ААН-үүд 12.2 тэрбум төгрөг /4.69 сая евро/-ийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нэг зээлдэгчид ногдож буй дундаж зээлийн хэмжээ 210.7 сая төгрөг байна (Хүснэгт 2).

Оролцогч банкуудаас төслийн хүрээнд эцсийн зээлдэгчид төгрөгөөр дамжуулан олгосон зээлийн ЖДХ жилийн 13.6 хувь, еврогоор дамжуулан олгосон эх үүсвэрийн ЖДХ жилийн 8.5 хувьтай байна.

Хүснэгт 2: КфВ төслийн зээлд хамрагдсан ЖДҮ-ийн тоо, авсан зээлийн хэмжээ /оролцогч банкаар/

Д/д	Оролцогч Банк	Нийт хамрагдсан ААН			Зээлийн үлдэгдэлтэй ААН		
		ААН-ийн тоо	Нийт олгосон зээлийн дүн /төгрөгөөр/	Нэг ААН-д оногдож буй зээлийн дүн	Зээлийн үлдэгдэлтэй байгаа ААН-ийн тоо	Зээлийн үлдэгдэл /төгрөгөөр/	Нэг ААН-д оногдож буй зээлийн дүн
1	Монгол шуудан	27	12 801 456 326,4	474 128 012,1	0	0,0	0,0
2	ХХБ	49	26 526 997 792,9	541 367 301,9	17	6 007 564 098,7	353 386 123,5
3	Капитрон	27	14 373 129 771,0	532 338 139,7	0	0,0	0,0
4	Голомт	33	7 527 868 880,0	228 117 238,8	29	4 573 511 741,3	157 707 301,4
5	УБХБ	13	2 669 300 000,0	205 330 769,2	12	1 637 735 237,8	136 477 936,5
	НИЙТ	149	63 898 752 770,32	428 850 689,7	58	12 218 811 077,89	210 669 156,5

КфВ төслийн ашиглаагүй эх үүсвэрийн үлдэгдэл 2016 оны эцсийн байдлаар 1,496.3 мянган евро байна.

2. АХБ-ны Ажлын байр нэмэгдүүлэх (АБН) төслийн зээл

Төслийн зорилго: Монгол улс, АХБ-ны хооронд байгуулсан зээлийн хэлэлцээрийн зорилго нь хувиараа хөдөлмөр эрхлэх хэлбэрээр жижиг үйлдвэрлэл эрхэлж буй иргэдийг дэмжих, мөн ажлын байр нэмэгдүүлэхэд оршино.

Эх үүсвэр: Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу 2154.0 мянган зээлжих тусгай эрхтэй (ЗТЭ) тэнцэх валютыг 40 жилийн хугацаатай зээлсэн.

АХБ-наас Монголбанкинд олгосон зээлийн эргэн төлөлт: Монголбанк АХБ-нд жилд 2 удаа хуваарийн дагуу эргэн төлөлт хийдэг бөгөөд хамгийн сүүлд 2016 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр 40,800.00 ЗТЭ-ийн зээлийн үндсэн өр, 7,356.36 ЗТЭ-ийн хүүгийн төлбөрийг эргүүлэн төлсөн.

Анх зээл авсанаас хойш нийт 767.3 мянган ЗТЭ-ийг төлж 2016 оны эцсийн байдлаар зээлийн өрийн үлдэгдэл 1,386.7 мянган ЗТЭ буюу 1.9 сая ам.доллар* байна.

*-2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн ханшаар тооцоход 4.6 тэрбум төгрөг байна.

Банкинд дамжуулан олгосон зээл: Банкнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монголбанк 30 сая хүртэлх төгрөгийг 3 жилийн хугацаатай банкуудад дамжуулан олгодог. Төслийн хүрээнд өссөн дүнгээр нийт 16.9 тэрбум төгрөгийн зээл банкинд дамжуулан олгосон. 2016 оны эцсийн байдлаар оролцогч банкинд олгосон эх үүсвэрийн үлдэгдэл 3.19 тэрбум төгрөг байна. Ингэснээр төслийн эргэлтийн санд зээлдүүлэх боломжтой 1.4 тэрбум төгрөгийн эх үүсвэр байна (Зураг 4).

Зураг 4. АХБ-ны АБН төслийн зээлийн үлдэгдэл, дамжуулан олгосон дүн



Эх үүсвэрийн ашиглалт

Төслийн эргэлтийн хөрөнгөд байршуулсан 3.2 тэрбум төгрөгийн эх үүсвэрийн 97.5 хувийг Голомт банк, 2.5 хувийг Улаанбаатар хотын банкаар дамжуулан иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгосон байна (Зураг 5).

Зураг 5. АХБ-ны АБН төслийн зээлийн эргэлтийн сангийн эх үүсвэрийн хуваарилалт



Банкуудын тайлангаас үзэхэд төслийн хүрээнд олгосон зээлийн үр дүнд зээл авсан ААН-үүд нийт 438 (Голомт банк 429, УБХБ 9) ажлын байр нэмэгдүүлсэн байна.

Банк	Зээлдэгчийн тоо	Нэмэгдүүлсэн ажлын байрны тоо
Голомт	201	429
Улаанбаатар хотын	4	9
	205	438